



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 3 нэрийн, нийт 8,520,675,764.35 (найман тэрбум таван зуун хорин сая зургаан зуун далан таван мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 4,260,337,870.96 (дөрвөн тэрбум хоёр зуун жаран сая гурван зуун гучин долоон мянга найман зуун далан төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баяндүүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005454
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны... дугаар сарын...-ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Нэгжийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ /төгрөг/	Цаашид ашиглах хугацаа /жил/	Шинэчлэн тогтоосон нийт үнэ /төгрөг/
1	ICP төхөөрөмж	2012.07.16	748	3,798,785.45	2,841,491,516.60	1,899,392.72	3	1,420,745,754.56
2	ICP төхөөрөмж	2012.07.16	748	3,798,785.45	2,841,491,516.60	1,899,392.72	3	1,420,745,754.56
3	ICP төхөөрөмж	2012.07.16	747	3,798,785.45	2,837,692,731.15	1,899,392.72	3	1,418,846,361.84
НИЙТ ДҮН				2243	8,520,675,764.35 (найман тэрбум таван зуун хорин сая зургаан зуун далан таван мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг гучин таван мөнгө)			4,260,337,870.96 (дөрвөн тэрбум хоёр зуун жаран сая гурван зуун гучин долоон мянга найман зуун далан төгрөг ерэн зургаан мөнгө)